

ЖИЛИЙН ТАЙЛАН

2013



ТЭНГЭР ДААТГАЛ

ГАРЧИГ

5	Компанийн тухай товч мэдээлэл
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
8	ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК
9	Зах зээлийн товч мэдээлэл
10	Компанийн засаглал
11	Төлөөлөн удирдах зөвлөл Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод
14	Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
16	Бидний стратеги, хөгжил
20	Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд
22	Даатгалын газрын тайлан
30	Эрсдэлийн газрын тайлан
38	Үйл ажиллагааны газрын тайлан
48	Хараат бус аудиторын дүгнэлт

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид даатгалын зах зээл дээрх мэргэжлийн стандартыг тогтоож, хүн төрөлхтний сайн сайхны төлөө үйлчилгээг үзүүлнэ.

ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС

Ногоон эх дэлхий - Бидний хариуцлага
 Мэргэжлийн өндөр ёс суртахуун - Шударга зах зээл
 Боловсролтой Монгол иргэн - Чадварлаг боловсон хүчин
 Эрсдэлгүй орчин - Амгалан харилцагч

ХЭТИЙН ЗОРИЛТ

Олон улсын стандартын дагуу корпорацийн эрсдэлийн удирдлагын цогц үйлчилгээ бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ.

Ухаалаг Монгол иргэнийг бий болгох үүднээс Монгол улсын иргэн бүрт даатгалын үйлчилгээг хүргэн үйлчилнэ.

Харилцагчийн халамжийн тогтолцоог шинэ түвшинд гарган харилцагч хэрэглэгчдэд ойр хамгийн сайн туслах нь байж халамжилна.

Нөхөн төлбөрийн үзүүлэлтийг өндөр түвшинд гарган түргэн шуурхай үйлчилнэ.

Нэр	Тэнгэр Даатгал ХХК
Эрхэм зүйлс	Ногоон Дэлхий – Бидний хариуцлага Мэргэжлийн ёс суртахуун – Шударга зах зээл
Хэтийн зорилт	Боловсролтой Иргэн – Чадварлаг боловсон хүчин Эрсдэлгүй орчин – Жаргалтай Харилцагч
Зорилго	Бид даатгалын зах зээл дээрх мэргэжлийн стандартыг тогтоож, хүн төрөлхтний сайн сайхны төлөө үйлчилгээг үзүүлнэ.
Байгуулагдсан он	2001
Төв оффисын хаяг	Сити Центер Төв, 11-н давхар, Тусгаар Тогтнолын Ордны хажууд, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Алтангэрэлийн гудамж, 5, 14200 Шуудангийн хайрцаг: 48/258, Улаанбаатар хот, Монгол улс
Төлөөлөн Удирдах Зөвлөл	Дарга: Амартүвшин Ганибал Гишүүн: 5
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх Захирал Галбадрахын Цогбадрах
Үйл ажиллагааны чиглэл	Даатгалын цогц үйлчилгээг үзүүлэх
Салбарын тоо	24
Байгууллагын төрөл	Хязгаарлагдмал хувьцаат компани
Вальютын төрөл	Төгрөг
Нийт хөрөнгийн хэмжээ	9,7 тэрбум төгрөг
Нийт ажилчдын тоо	96 (2013/12/31)
Ажилчдын дундаж нас	29,6 нас
Хүйсийн харьцаа	53% эмэгтэй, 47% эрэгтэй

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Г. Амартүвшин
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Эрхэм хүндэт даатгуулагч, хамтран ажиллагч түншүүд, хувьцаа эзэмшигчид ээ,

Өнгөрөгч 2013 он ТэнГэр Даатгал ХХК-ийн хувьд томоохон онцлох үйл явдлуудаар дүүрэн тэмдэглүүштэй жил боллоо.

Өнгөрөгч он бидэнд аз турших хэрэггүй болохыг, эрсдэлийг боломжит хамгийн сайн хувилбараар таамаглаж, илрүүлж, түүнийг удирдах учиртайг харуулсан олон үйл явдлууд тохиолдлоо.

“ТэнГэр Даатгал” компани нь иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн өргөн хүрээтэй, эрсдэлийн шийдэл бүхий даатгалын хамгаалалтыг санал болгон Монголын даатгалын зах зээл дээр баттай байр сууриа эзэлсэн даатгалын салбар дах тэргүүлэгч компани болохын төлөө тулгараад буй хүндхэн эрсдэлүүдийн эсрэг Лангуу түрээслэгчийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулан гаргаж, нийт жижиг дунд бизнес эрхлэгчиддээ хандсан эрсдэлийн томоохон сургалтуудыг шат дараалан амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн Барилга угсралтын даатгал, байгууллагын хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнүүдийг төгөлдөршүүлж, дэлхийн топ давхар даатгагч “Hannover re”-тэй хамтран ажилласнаар багц эрсдэлүүдийг шилжүүлэн ажиллах өндөр чадамжтай боллоо.

ТэнГэр Даатгал нь 2013 оны эхэнд Монгол улсын даатгалын салбарын тэргүүлэгч компаниар дахин өргөмжлөгдөж, нийт хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэн 9,7 тэрбум төгрөгт хүргэж ажиллаа. Компанийн ийнхүү ажиллахад нөлөөлсөн томоохон хүчин зүйлүүд нь урт хугацааны туршид компанийн засаглалын сайн туршлагуудыг нэвтрүүлж байсан шат дараалсан үйл ажиллагаа, үндэсний зах зээл дээрх хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг бөгөөд мөн түүнчлэн даатгуулагчдын итгэлийг даан ажиллаж ирсэн олон жилийн туршлага болон компанийн өндөр хариуцлага юм.

ТэнГэр Даатгал ХХК-ийг харилцагчийн иж бүрэн цогц үйлчилгээтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч даатгалын компанийн байр суурийг бэхжүүлэн хадгалах талаар олон чухал алхам хийж, амжилттай ажиллаж ирсэн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, түүний удирдлагын баг, нийт ажиллагсдад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өмнөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

2013 оны 9 дүгээр сард ТэнГэр Даатгал ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн компани боллоо. Өнгөрсөн он жилүүдэд ТэнГэр Даатгал ХХК, түүний ТУЗ-ийн үйл ажиллагаанд итгэж, дэмжиж, байсан үүсгэн байгуулагч Петровис ХХК-д онцгойлон талархал илэрхийлье.

Мөн толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувь нийлүүлэгчид, сэтгэл зүрхээ зориулж хамтран ажилладаг Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүддээ баярлалаа. Мөн эрхэм даатгуулагчиддаа, хамтран ажиллагч түншүүддээ 2013 оныг ололт амжилтаар дүүрэн байлгахын төлөө хичээн ажилласан компанийн хамт олондоо, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн, хамтран ажилласан нийт төрийн болон төрийн бус байгууллагуудад гүн талархал илэрхийлье. Компани 2018 он хүртэлх стратеги, бизнес төлөвлөгөөгөө баталж, энэхүү төлөвлөгөөний дагуу Компанийн брэнд, дүр төрхийг шинэчлэн сэргээх, бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнд суурилсан харилцагчид ээлтэй, ухаалаг үйлчилгээний загварыг даатгуулагчийн сегментэд суурилсан тогтолцоогоор өөрчлөх алхмууд хийгдээд байна.

Бид Монгол улсын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, даатгуулагчийн өдөр тутмын амьдрал, хүрээлэн буй орчинд учирч буй эрсдэлүүдийг удирдах орчин үеийн арга аргачлал, эрсдэлийг амжилттай удирдах үр ашигт дотоод бүтэц тогтолцоо, эрсдэлийн удирдлагаар эрсдэлийг таньж илрүүлэх, эрсдэлийг амжилттай хаах тогтвортой хөгжлийн загварыг хэрхэн бий болгох зэрэг асуудлыг бодлогын болоод практик түвшинд хэрэгжүүлэхийн тулд нийт даатгуулагчидтайгаа хамтран ажиллахын зэрэгцээ Монгол Улсын эдийн засаг түүний дотор даатгалын салбарын хөгжилд өөрийн өнгө аяс, дуу хоолойгоор хүч нэмж, даатгалын компанийн засаглалын тэргүүн туршлагуудыг нэвтрүүлж нийгмийн хариуцлагаар манлайлагч байгууллагын байр сууриа цаашид бэхжүүлэхийн тулд хичээн ажиллах болно.

Тэнгэр Санхүүгийн нэгдэл нь 1998 оноос орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төслөөс гараагаа эхлэн 2001 онд Хөгжлийн Алтан Сан ба Говийн Эхлэл гэсэн хоёр банк бус санхүүгийн байгууллага нэгдэж Х.А.С – ГЭ групп нэртэйгээр байгуулагдсан. Улмаар банк бус санхүүгийн гурав дахь байгууллага болох хадгаламж зээлийн NetMon-той хамтран ажиллахаар болсон юм.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл нь иргэд болон бизнесменүүдийн хүрээнд санхүүгийн том сүлжээ бүхий групп үүсгэх зорилготой. Энэхүү групп нь бизнесийн хамгийн өндөр шалгуурыг дагаж мөрдөх бөгөөд байгаль орчиндоо ямагт хариуцлагатай хандаж ажилласаар байна.

2009 онд Дэлхий нийтийн ашиг тусын холбооны гишүүн болсноор хөгжлийн төлөө санхүүжилтийн тэргүүн гэдгээ харуулж чадсан юм. 2012 онд Тэнгэр нь Олон Улын Санхүүгийн Корпораци /ОУСК/ зэрэг бусад 4 хөрөнгө оруулагчидтай хамтран анхны Сино-Монголиа Бичил Санхүүгийн Байгууллагыг байгуулсан билээ.

Олон улсын түвшний санхүүгийн мэдлэгийг хөрөнгө оруулагчдын туршлагатай хослуулсан ТянРоны хувьд БНХАУ-ын Шинжанаас эхлэн нийт Төв Азийн бүс нутагт бичил санхүүгийн салбарт ийнхүү тэргүүлэгч болох онцгой нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Тэнгэр Санхүүгийн Нэгдэлд ХасБанк, ХасЛизинг, ХасСекьюрити, Тэнгэр Даатгал, ТянРон Кредит болон Тэнгэр Капитал зэрэг компани багтдаг. Тэнгэр хэмээх бүс нутгийн компаниудын бүлэг нь нийтийг хамарсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилготой ажиллаж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД


Тэнгэр Даатгал ХХК-ийн нэгж хувьцаанд ногдох ашиг жил тутам тогтвортой өсч буй нь Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлсээр байна.

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн дагуу тус хорооны 8 дугаар сарын 28-ны өдрийн 286 тоот тогтоолоор Петровис ХХК-ийн өмчлөл дэх “Тэнгэр Даатгал” ХХК-ийн хувьцааны 50 хувийг “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-д худалдахыг зөвшөөрсний дагуу 2013 оны 9 дүгээр сард тус ажлууд хийгдэж “Тэнгэр Даатгал” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 100% ийн эзэмшлийн охин компани боллоо.


Энэхүү үйл явдал нь компанийн бизнесийн байр суурийг улам ихээр бэхжүүлэх, даатгуулагч, иргэд, харилцагч байгууллагад банк санхүү, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цогц байдлаар шинэ шатанд хүргэхэд томоохон түлхэц болоод зогсохгүй Монголын санхүүгийн салбарт шинэ жишгийг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боллоо.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь Монгол улсын өнцөг бүрт хүрсэн санхүүгийн цогц үйлчилгээ ард иргэдэд үзүүлдэг ХасБанк ХХК, түүний харуул хамгаалалт хариуцсан ХасСекьюрити ХХК, санхүүгийн түрээс олгох чиглэлээр ХасЛизинг ХХК, Корпорацийн санхүү, борлуулалт, худалдаа, зөвлөгөө, компанийн нэгдэл, эзэмшил зэрэг үйлчилгээг үзүүлдэг цогц хөрөнгө оруулалтын банк болох Тэнгэр Капитал ХХК, БНХАУ-д байрлах Бичил-Санхүүгийн Институт болох ТианРон зэрэг охин компаниудыг эзэмшиж цаашид бүс нутагт хөрөнгө оруулах, техникийн туслалцаа үзүүлэх стратегийн чиглэл бүхий холдинг буюу толгой компани юм.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц 2013 оны 8 дугаар сарын байдлаар




Хувьцаа эзэмшигчдийн бүтэц 2013 оны 12 дугаар сарын байдлаар




Даатгалын компаниудыг 2013 оны 4 дүгээр улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 28 хувь буюу 24.971 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 13 хувь буюу 11.879 сая төгрөгийг, “Тэнгэр даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 9 хувь буюу 8.512 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 60 хувийг эзэлсэн байна.


НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО (сая төг)



2013 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-ийн хөрөнгө даатгагчдын нийт хөрөнгийн 31 хувийг эзэлж, “Гэр даатгал” ХХК-ийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө хамгийн бага буюу зах зээлийн нийт хөрөнгийн 2.3 хувийг эзэлж байна.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО (сая төг)





Тэнгэр Даатгал компанийн удирдах зөвлөлийн ерөнхий зарчим нь:

- Хариуцлага;
- Шударга Ёс;
- Ил тод байдал;
- Үүрэг хариуцлагад үндэслэгдэнэ.

Энэхүү зарчим нь манай үйл ажиллагааг сайжруулах, ил тод байдлыг баталгаажуулах, компанийн үүрэг зарчмыг цаашид хөгжүүлэн харуулах үүрэгтэй бөгөөд *Хариуцлагатай, Найдвартай, Үр дүн дээр суурилсан удирдлага* юм.

Компанийн нийт хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийн төлөө хяналттай ажиллан үр ашгийг тогтвортойгоор нэмэгдүүлэх, зохистой мэдээлэлүүдийг ил тод байдлаар илрүүлэх, эрсдлийг багасгах ба дотоод хяналтыг сайжруулахад чиглэсэн хамгийн сайн засаглалтай тэргүүлэгч компани юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХОРООД

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх компанийн удирдлага, гадаад харилцааны стратеги, хөрвөх чадвар, гадаад солилцоо, улс төр, үйл ажиллагаа, нэр хүнд болон хянан нийцүүлэхтэй холбоотой компанийн олон талт эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэнд мониторинг хийх, үнэлгээ өгөх зэрэг чиглэлээр ажилладаг, эрсдэлийг зохистой хэмжээнд барих үүргийг тус хороо хүлээдэг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

Та бүхэнд тус компанийн 2013 оны компанийн засаглалын тайлан, үзүүлэлтүүдийг танилцуулж байгааг хүлээн авна уу.

"Компанийн засаглал гэдэг нь байгууллагын бүхэлд нь хамарч гэрэлтсэн нарны тухай асуудал юм" гэж Пакистан дахь Kashf Microfinance Bank ХХК-ийн Гүйцэтгэх захирал Roshaneh Zafar хэлсэн байдаг.

Компанийн сайн засаглал, тэргүүн туршлага нь компанийг хянах, чиглүүлэхэд шаардлагатай дүрэм журам, зохион байгуулалтыг тогтоодог ба мөн түүнчлэн компанийн үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн төлөө төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүрэг, менежментийг чиглүүлж, хянах журмыг тодорхойлдог. Энэхүү процессчилогдсон ил тод, хяналттай, үүрэг хариуцлагад үндэслэгдсэн байдал нь компанийн эрчимтэй хөгжлийн эх үндэс, харилцагчид, даатгуулагчдын найдвартай байдал төрүүлэгч хүчин зүйл болдог нь дамжиггүй.

Тус компанийн засаглалын хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2007 онд баталсан Корпорацийн засаглалын зарчмууд, Даатгалын салбарын компанийн засаглалын кодекс мөн түүнчлэн Толгой компанийн Корпорацийн засаглалын код зэрэгт үндэслэн Компанийн засаглалын зарчмуудыг мөрдөх үүргээ тодорхойлох зорилгоор 2013 оны 11 дүгээр сард Компанийн корпорацийн засаглалын кодексыг баталлаа. Үүгээрээ хувьцаа эзэмшигчдийн үнэн бодит мэдээлэл хүлээн авах эрх, хяналт хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх байдал, ил тод байдал ба тайлагнал, оролцогч талуудын өмнө үүрэг хариуцлага хүлээх зарчимд суурилсан Компанийн засаглалын ерөнхий бүтцийг тодорхойлж байгаа юм.



АУДИТЫН ХОРОО

Аудитын Хороо нь хууль тогтоомж бусад журам зааварт нийцэж ажиллаж байгаа эсэх, хөндлөнгийн аудитын бие даасан байдалд үнэлэлт өгөх сонгон шалгаруулах, компанийн дотоод хяналтын албаны болон хөндлөнгийн аудитын ажлын гүйцэтгэлд хяналт тавих болон аудиторруудаас тайлан авах, тэдэнтэй уулзах, тэдний гаргасан санал хүсэлтэд хариу өгөх зэргээр хянах үүргийг тус хороо хүлээдэг.

Хувь нийлүүлэгчдийн эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим, мэдээллийн ил тод байдал, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагын тогтолцоо болон компанийн удирдлагын зүй зохистой бүтэц суурийг бүрдүүлэх гэсэн гол зарчимд компанийн засаглал тулгуурладаг.

Эдийн засгийн тогтвортой хөгжил, бизнесийн орчны таатай нөхцлийг бүрдүүлэхэд хууль ёсыг дээдэлсэн хариуцлагын ил тод тогтолцоог бүрдүүлэхэд зогсохгүй хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх компанийн зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид эрхээ хэрэгжүүлэх бодит боломжийг бүрдүүлэн, ноогдол ашиг хуваарилах ажиллагаанд саадгүй хамрагдах, хувьцаа эзэмшигчид компанийн талаарх мэдээллийг тогтмол болон цаг тухай бүрт шуурхай авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Бид уламжлалт олон шатлалт зохион байгуулалтын бүтцийг халж, илүү уян хатан, удирдлага болон ажилчид, албадуудын хоорондын мэдээллийн урсгалыг илүү чөлөөтэй, найдвартай болгох тойрог хэлбэрийг сонгон үйл ажиллагаагаа явуулж байна.

Даатгуулагч, ажилчид болон хувьцаа эзэмшигчдийн аль алины сонирхлыг хамгаалах, тэдгээрийн төлөөлөл болсон гишүүдээс бүрдсэн Төлөөлөн удирдах зөвлөл нь бүх талын эрх ашигт нийцсэн тэнцвэртэй шийдвэр гаргадаг ба Тэнгэр Даатгал ХХК-нийн засаглалын ялгарах онцлогуудын нэг юм.



Баруун дээд талд ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гантулга
Зүүн дээд талд ТУЗ-ийн гишүүн Ц.Болор
Баруун доод талд ТУЗ-ийн дарга Г. Амартүвшин
Зүүн доод талд ТУЗ-ийн гишүүн Г.Цогбадрах

ТУЗ-ийн дарга Г.Амартүвшин

2011 оны 4 дүгээр сард томилогдсон,

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Ерөнхий захирлаар 2011 оны 4 дүгээр сараас эхлэн ажиллаж байна.

Тэрбээр Казахстан улсын арилжааны томоохон банк болох Казкоммерц банкны эрсдлийн удирдлагын газрын дарга, ерөнхий захирлын алба хашиж төслийн санхүүжилт болон зээлийн санхүүжилтийн чиглэлээр арваад жил ажилласан туршлагатай.

Казкоммерц банкинд ажиллахын өмнө Г. Амартүвшин нь ABN AMRO Банкны Лондон, Амстердам болон Чикаго хотуудын салбарт ажиллаж байв. ABN AMRO банкны бүтцийн зээлийн хэлтэст ажиллаж байхдаа Европын газрын тос, шатдаг хий, эрчим хүч, харилцаа холбоо гэх мэтчилэн хэд хэдэн өндөр хэмжээний гүйлгээг хариуцан ажиллаж байжээ. Г.Амартүвшин нь хөдөлмөрийн гараагаа ABN AMRO дахь бэлэн мөнгөний менежментийн газраас эхэлсэн бөгөөд улмаар тэндээ Ерөнхий Эрсдэлийн Удирдлагын хэлтэст шилжин оржээ.

Тэрээр Бельги улсын Брюссель хотын Европын Их сургуулийн бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй бөгөөд АНУ-ын Бостон хотын Харвардын бизнесийн сургуулийн, бизнесийн удирдлагын магистрын дипломыг гардан авсан билээ.

ТУЗ-ийн гишүүн Г.Цогбадрах

2012 оны 3 дугаар сард томилогдсон,

Г.Цогбадрах нь 2011 оны 3 дугаар сараас эхлэн ТэнГэр Даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

АНУ-д магистрийн зэрэг хамгаалж ирсний дараа ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтнээр ажиллаж байв. Г.Цогбадрах нь 2000 онд Х.А.С. үндэсний банк санхүүгийн байгууллагад салбарын менежерээр ажиллаж байсан ба тус банкинд хэд хэдэн албан тушаал дээр ажиллаж байсны нэг нь ХасБанкны Мөнгөн сангийн хэлтсийн дарга, салбарын удирдлагын хэлтсийн захирал зэрэг болно.

Г.Цогбадрах нь иргэдийн банкны санхүүгийн удирдлага, дотоод аудит хяналт ба мөнгөн сангийн чиглэлээр 10 гаруй жил ажилласан ажлын баялаг туршлагатай. Тэрээр Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийн санхүүгийн удирдлага банкны ангийг төгссөн бөгөөд АНУ-ын Лос-Анжелес хотын үндэсний сургуулийн Бизнес Удирдлагын магистр зэргийг санхүүгийн удирдлагын мэргэжлээр хамгаалсан болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гантулга

2011 оны 8 дугаар сард томилогдсон,

Доноровын Гантулга нь Гэрэгэ Партнерс ХХК-ийн Удирдах Түнш ба 2009 оны 1 дүгээр сард үүсгэн байгуулагдсан цагаас хойш Гэрэгэ Партнерсийн стратегийн хөгжлийн чиг хандлага болон өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллаж байсан.

Гантулга нь актуарын зөвлөгөө өгөх, бизнесийн үнэлэлт дүгнэлт, тэргүүлэх зөвлөх, удирдлагыг зөвлөх ба компаний менежментээр ажиллаж байсан туршлагатай. Тэрээр удирдлагын зөвлөл, татварын эд хөрөнгийн битүүмжлэл, активын үнэлэлт дүгнэлт болон орон нутгийн зах зээлийн судалгааны мэргэжлийн төслүүдийг ахлах ажиллаж байсан. Гантулга нь актуарын мэргэжлийг Монгол улсад хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ба Монгол Улсын Актуарчуудын Нийгэмлэгт Удирдах Гишүүнээр ажилладаг. Английн Гранд Торнтон ХХК болон Монголын Актуарын Нийгэмд ажиллаж байсан.

Актуарын мэргэжлийн стандарт, Олон Улсын Санхүүгийн Тайлангийн стандарт болон санхүүгийн тайлангийн талаар өргөн мэдлэгтэй гишүүн юм. Түншийн хувьд Гантулга нь Санхүүгийн Үйлчилгээний Зөвлөгөө, Үнэлэлт, Дүгнэлтийн газрыг ахлаж байсан ба Монгол улс дахь төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, тэр дундаа Санхүүгийн Зохицуулах Хороо болон голлох даатгалын компанид маш олон төслүүдийг удирдаж байсан. Гантулга нь Английн Манчестер Метрополитаны их сургуулийн Бизнесийн сургуульд магистрийн зэрэг горилсон болно.

ТУЗ-ийн гишүүн Ц.Болор

2011 оны 4 дүгээр сард томилогдсон,

Ц.Болор нь сүүлийн 7 жилийн хугацаанд ТэнГэр Группэд хөрөнгө зохицуулалт, зээлийн санхүүжилт, санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр ажиллаж ирсэн билээ. Киргиз Улсад Группийн хараат компани байсан бичил зээлийн компанид санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан ба улсын төсвийн санхүүгийн бодлого боловсруулалт, эдийн засгийн салбарын судалгаа мөн даатгалын бизнесийг хөгжүүлэх чиглэлээр ажлын арвин туршлагатай.

Ц.Болор нь Лондонгийн Сити Их Сургуулийн дэргэдэх Кассын нэрэмжит Бизнес Сургуулийн Банк ба ОУ-ын санхүүгийн ШУ-ны Магистр ба МУИС-ийн ЭЗДС-ийн санхүүгийн удирдлага ба даатгалын бакалаврын зэрэгтэй.

2013 оны 9 дүгээр сард чөлөөлөгдсөн гишүүд

Д.Энхмаа, Петровис ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Л.Отгонболд, Петровис ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн ахлах менежер

Ч.Номин, Монгол HD телевизийн Захирал

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Г.Цогбадрах
Гүйцэтгэх захирал

ТэнГэр Даатгал ХХК-ийн хувь нийлүүлэгч, хүндэт даатгуулагчид, бизнесийн түншүүд хамтран ажиллагч давхар даатгагчид болон энэхүү тайланг дэлгэн уншиж буй эрхэм Танд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бидэнд эрсдэл, амжилт, өндөр үр дүнг дагуулсан 2013 оны ажлын тайлангаа танилцуулж буйдаа туйлын таатай байна.

2013 онд Монгол улсын хэмжээнд дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал болон уул уурхайн зах зээлийн үргэлжилсэн сулралаас үүдсэн эрсдэл давамгайллаа. Эдийн засагт гадны хөрөнгө оруулалтын урсгал багассан, уул уурхайн экспорт сул байгаатай холбоотойгоор төлбөрийн тэнцэл тогтворгүй байсан ч сүүлийн саруудад хэд хэдэн томоохон эерэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний дотор Хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль батлагдсан, төсвийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулсан эерэг үйл явдал давхацсан нөхцөл байдал, гадаад болон дотоод орчны сөрөг нөлөөллийн эрсдэл их байсан боловч ТэнГэр Даатгал ХХК-ийн хувьд өмнөө тавьсан гол зорилтуудаа биелүүлж, зах зээл дэх өрсөлдөх чадвар, даатгал, санхүүгийн зах зээл дээр эзэлсэн байр сууриа хадгалж 65,000 даатгуулагчийн 3,3 их наяд төгрөгийн эрсдэлийг амжилттай удирдаж чадлаа.

Бид анх удаа монгол хүн бүрт хүргэх зорилготой дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт даатгалын үйлчилгээ болох онлайн даатгалд хамрагдах, төлбөр тооцоог гүйцэтгэх, нөхөн төлбөртэй холбоотой бүхий л үйлчилгээг түргэн шуурхай хүртээх, гар утастай хүн бүр байнгын хэрэглээ болгон ашиглаж, даатгалын үйлчилгээг хялбар, шуурхай хүртээсэй хэмээн хүсч, эрмэлзэн ажиллаж mobile insurance үйлчилгээг нэвтрүүлэхээр 2013 оноос сургалт хийн ажиллаж, нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна.

Энэхүү жилийн тайланд байгаа мэдээллүүд нь уншигч танд ТэнГэр Даатгал ХХК-ийн 2013 оны ололт амжилтууд болон даатгалын салбарын мэдээ мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүйгээр сонордуулна гэдэгт итгэж байна. Өнгөрсөн жилийн хугацаанд амжилт ололт бүхэнд бидэнтэй хамт байж, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхийг зорьж ажилласныг үнэнчээр дэмжиж ирсэн нийт даатгуулагч, гадаад дотоодын түншүүддээ халуун талархал илэрхийлье.

Хэдийгээр эдийн засгийн болон санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан олон сорилт, эрсдэлүүд бидэнтэй мөр зэрэгцэн алхаж байгаа ч ирж буй он бидний хувьд өөдрөг, боломжийг дагуулсан онцгой жил байлаа. Таны итгэлийг дээдэлсэн ТэнГэр Даатгал ХХК-ийн хүндтэй даатгуулагч, бизнесийн түншүүд, хувьцаа эзэмшигч та бүхний бизнесийн ашиг орлого өөдөө, амьдрал тань улам цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе.

2014 он бидний хувьд өөдрөг, гялалзсан амжилтаар дүүрэн жил байх болтугай.

БИДНИЙ СТРАТЕГИ, ХӨГЖИЛ

СТРАТЕГИ

Тэнгэр Даатгал компани нь эрхэм зорилгынхоо хүрээнд компанийн сайн засаглалыг тогтоож, үйл ажиллагааны ил тод, тунгалаг байдлыг нэмэгдүүлж, харилцагчдын өмнө компанийн үйл ажиллагааг нээлттэй байлгах зарчмыг баримталж ажилласнаар Монголын даатгалын салбарт эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

Бид үйл ажиллагаандаа мэргэжлийн ёс зүйг эрхэмлэж, эрхэм харилцагч нарынхаа хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, олон улсын түвшинд хүрсэн даатгалын цогц бүтээгдэхүүн, үйлчилгээг даатгалын зах зээлд нэвтрүүлэн, харилцагчийн эргэх холбоо, харилцагчийн халамжийн үйлчилгээ, нөхөн төлбөрийн шуурхай байдал, харилцагч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэн ажиллаж байна.

ХӨГЖИЛ

Аливаа компанийн хөгжил нь байгаль орчин, нийгмийн хариуцлага ба компанийн хүний нөөц болон хууль дээдлэх соёл, дотоод хяналт гэсэн үндсэн хүчин зүйлүүдэд тулгуурладаг. Түүнчлэн группын хэмжээнд баримталдаг гурван үндсэн зарчимд тулгуурлан,

- **Эх дэлхий** – Нийгмийн хариуцлага, байгаль орчны бодлогын хүрээнд бидний явуулж буй аливаа үйл ажиллагаа хамтран ажиллаж буй байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд эерэг нөлөөллийг үзүүлж, харилцагч иргэдийн аж амьдралд сайнаар нөлөөлөхүйц үр дагавартай байхад анхаарч, энэ нь эргээд бидний амьдран буй эх дэлхийд сөрөг нөлөөллийг үзүүлэхгүй байхад анхааран ажиллаж байна.
- **Эрдэнэт хүмүүн** – Компанийн хүний нөөцийн мэдлэг, чадвар, боловсролыг нэмэгдүүлж дотоодын болон олон улсын сургалтуудад хамруулах замаар салбарын болон бусад салбарын мэдлэгийг дээшлүүлэх, манлайлах чадвар, сэтгэл ханамжийг сайжруулахад анхааран, харилцагчдыг аливаа шалгуураар эрэмблэх, ялгаварлан гадуурхахгүй байж тэдний даатгалын боловсролыг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, тэгш байх зарчмыг баримталж, хүний эрхийг дээдлэн ажиллаж байна.
- **Эрүүл ашиг** – Даатгалын салбарын хууль эрх зүйн хүрээнд Компанийн бодлого, дүрэм журмыг нийцүүлэн, Монгол улсын болон олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэх, компанийн дотоод хяналтад олон улсын стандартыг хэрэгжүүлэн, эрсдэлийн удирдлагыг илүү боловсронгуй болгож сайжруулснаар компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд зорин ажиллаж байна.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



ТЭНГЭР ДААТГАЛ
Танин Эрхдэлийн МЕНЕЖЕР

Тэнгэр даатгал компани нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл болон Петровис компанийн хөрөнгө оруулалттайгаар 2001 онд байгуулагдсан.

Монголын даатгалын зах зээлд арав гаруй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилладаг харилцагчдын итгэл найдварыг бүрэн хүлээсэн даатгалын салбар дах тэргүүлэгч компани юм.

Харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилласнаар харилцагчдын итгэл, найдварыг бүрэн хүлээж, хариуцлагатай, ил тод байдлыг эрхэмлэхэд чиглэсэн хамгийн сайн засаглалтай даатгалын салбар дахь тэргүүлэгч компанийн нэг юм. Тэнгэр даатгал ХХК нь санхүүгийн ил тод үйл ажиллагаатай, нийгмийн хариуцлага, хамтын ажиллагааны цар хүрээ, үр дүнд суурилсан удирдлага, сайн засаглалыг баримтлагч зэргээрээ Монголын даатгалын зах зээлд тэргүүлсээр байх болно.

2013 оноос Тэнгэр Санхүүгийн нэгдэл 100 хувийн хөрөнгө оруултыг хийснээр компанийн бизнесийн байр суурийг улам ихээр бэхжүүлэх, даатгуулагч, иргэд, харилцагч байгууллагад банк санхүү, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цогц хэлбэрээр шинэ шатанд хүргэхэд томоохон түлэх болоод зогсохгүй Монголын санхүүгийн салбарт шинэ жишгийг нэвтрүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэх болно.



9,7 тэрбум
Компанийн нийт актив 30 %-иар өсөж 9,7 тэрбум төгрөг давлаа.

20%
Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оноос хорин хувиар өслөө.

Тэтгэврийн нэрийн данс
Ажилчдын тэтгэврийн нэрийн дансыг шинэчлэн ирээдүйд нь хөрөнгө оруулалт хийлээ.

Түншлэл
Түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсын томоохон 5 банкт хамтран ажиллах үйл ажиллагааг сайжрууллаа.

Эрсдлийн удирдлага

Харилцагчийн халамжийн хүрээнд харилцагч байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн шинжилгээг олон улсын түвшинд хийж, зөвлөгөөг өгч ажиллаа.



Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлж урлаг, спортын хамтын ажиллагааг шинэ шатанд хүргэн дэмжиж ажиллаа.



МҮХАҮТ-ын "Оны онцлох Энтрепренер" номинаци, Хүрэл меркури буюу "Сайн засаглалыг хэрэгжүүлэгч" компани шагналын эзэнээр 4 дэх жилдээ тодорлоо.



"ТэнГэр Санхүүгийн Нэгдэл" компанийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани боллоо.



Хүний нөөцийн цогц систем бүхий Green ERP программыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлээ.

41%
2013 оны даатгалын хураамжийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж өмнөх оноос 41%-иар нэмэгдлээ.

Гадаад хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж Герман, Англи, Солонгос, Япон улсын даатгалын компаниудтай уулзалтуудыг зохион байгуулж хамтын ажиллагааг өргөжүүллээ.



Бага дунд орлоготой иргэдэд зориулсан "Тэнгэрлэг Монгол Иргэн" багц даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлээ.



Хөдөө орон нутгийн салбарын үйл ажиллагааг дэмжин өөрийн байртай, автомашинтай жишиг салбаруудыг бий болголоо.



2013 оны Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч "Тэргүүний байгууллага"-аар шалгарлаа.

"Монголын даатгагчдын холбоо"-ноос жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг СПОРТЫН НААДМЫН ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ЭЗНЭЭР 3 ДАХЬ УДААГАА тодорч амжилтаа дахин бататгалаа.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



БИДНИЙ ИРЭЭДҮЙ СУРАГЧ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригт бүх нийтээр “Мод тарих үндэсний өдөр” болгон зарласан билээ. Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч манай байгууллагын хувьд жил бүр “Мод тарих үндэсний өдөр”-т нийт ажилчид хамт олноороо нэгддэг билээ. Сонголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр сургуулийн хашаанд мод тарин, Монголын хойч ирээдүй болсон хүүхэд багачууддаа тусаллаа. Мөн хүүхдүүдийг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох эцэг эхчүүдийн өөрсдөө үлгэрлэх аяныг амжилттай зохион байгуулж ерөнхий боловсролын 5 сургуулийн өмнөх гарцаар 10250 зорчигч сурагчдыг гаргаж замын хөдөлгөөний дүрмийг танилцуулан үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилийн баярын өдрөөр ажиллагсдын хүүхэд багачуудыг хүлээн авч урлаг спортын тэмцээнийг зохион байгуулан тэднийг урамшуулж гарын бэлэг өгч баяр баягаланг бэлэглэн ажиллаа.



БИДНИЙ ХОЙЧ ҮЕ – ОЮУТАН

Компаний дэргэдэх Оюутан Клубын үйл ажиллагааг идэвхжүүлэн эрсдэлийг болохоос нь өмнө багасгах зорилгоор “Өөрсдөө үлгэрлэе” аяныг оюутан клуб, Замын Цагдаагийн Ерөнхий Газартай хамтран нийт масс иргэдэд замын хөдөлгөөний эрсдэлээс хэрхэн сэргийлэх, ерөнхий боловсролын сургуулийн ачаалал ихтэй замд зохицуулагч хийн уриалга лоозон барьж, бага ангийн сурагчдад зам хөндлөн гарахад нь туслан амжилттай ажиллаа. Мөн түүнчлэн эдийн засгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудыг дадлагажуулах болон оюутныг цагийн ажлаар хангах засгийн газрын хөтөлбөрийг дэмжиж тэдэнд цагийн ажлаар хангаж санхүүгийн хөрөнгө оруулалтыг хийн ажиллаа. Цаашлаад оюунлаг гэрэлт ирээдүйн боловсон хүчин бий болох зорилгоор оюутнуудаа дэмжин ажлын байраар ханган ажиллах төсөл хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.



УРЛАГ-КИНО-СПОРТ-ТӨСЛҮҮД

Кино урлагийг дэмжин нийт иргэдийн соёлын боловсрол, даатгалын талаарх зөв ойлголт, мэдээллийг хүргэх зорилгоор дараах кино төслүүд уран бүтээлчдийг дэмжин ажиллаж байна.



“ДҮҮЛЭН НИС” УСК

Нэр хоногшуулах байгууллагын имидж бүрдүүлэх, нийгмийн хариуцлагыг манлайлан хэрэгжүүлэх зорилгоор кино урлагийг дэмжиж хамтран ажиллаа.

“НАРНЫ ЖИМ” ОАУСК

ОБЕГ-тай хамтран ард иргэдийг аливаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, даатгал нийгэмд ямар хэрэгтэй талаарх зөв ойлголтыг хүргэх зорилгоор тус киног ивээн тэтгэн хамтран ажиллаж байна.



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО

Багаараа хөгжих багийн спортыг дэлгэрүүлэн хөгжүүлэх, иргэдийн эрүүл мэнд чийрэгжилтийг дэмжих зорилгоор тус холбоог ивээн тэтгэн хамтран ажиллаа.

ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВАА

Үндэсний спортын төрөл болох үндэсний шагайн харвааг хөгжүүлэн дэлгэрүүлэх зорилгоор компаний хэмжээнд баг тамирчдыг бэлтгэн санхүүгийн туслалцааг үзүүлэн Улсын баяр наадамд амжилттай оролцлоо.

МӨСӨН УУЛЫН АВИАЛТЫН КЛУБ

Уулын авиралтын тамирчдыг гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх сургалт зөвлөгөөг өгч тэднийг даатгалд хамруулан тамирчдын сэтгэл зүй болон санхүүгийн туслалцааг үзүүлэн хамтран ажиллаа.

МОНГОЛЫН ХӨЛ БӨМБӨГИЙН ХОЛБОО

Өсвөрийн тамирчдын амжилтыг дээшлүүлэх, багын спортыг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих зорилгоор нийслэлийн тусгай сургуулийг ивээн тэтгэж баг хамт олноороо амжилттай оролцлоо.

“MY MONGOLIA” СОЁЛЫН ӨВ ХАМГААЛАХ ТӨСӨЛ

Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа эртний иргэншлийн түүх, соёлын дурсгалт зүйл болох олон арван хүн чулуу, буган хөшөө, хадны сүг зураг, гэрэлт хөшөө, хадны бичээс, хиргисүүр, эртний сүм хийдийн үлдэгдэл, туурь, Азийн гадагш урсгалгүй ай савын бүхий л хэв шинжийг тусгасан газарзүйн өвөрмөц тогтоц, байгалийн онцлог үзэсгэлэн, амьтан ургамлыг харуулсан судалгааны зураг авалт хийж, танин мэдэхүйн нэвтрүүлгийг бэлтгэн хүүхэд залуучуудын мэдлэгийг дээшлүүлэх, боловсрол олгох төслийн ажиллагааг дэмжин ажиллаж амжилттай хэрэгжүүлэн явагдаж байна.

ЭХ ДЭЛХИЙ БИДНИЙ ХАРИУЦЛАГА

Бид нийгмийн хариуцлагаа ухамсарлан биелүүлэх үүднээс салбартаа тэргүүлэн жил бүр уламжлал болгон тусгай сургуулийн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэн тус сургуулийнхний талархлыг хүлээн авч ажиллаж байна. Мөн эх дэлхий байгалиа хамгаалах, онгон байдлыг хадгалан хойч үедээ үлдээх зорилгоор жил бүр группын хэмжээнд явган аялал зохион байгуулж, булаг, шанд, усаа хайрлан хамгаалах, хашаа хамгаалалтын байгууламжийг хүн бүр гар бие оролцон хийж бүтээдэг сайхан уламжлал тогтоон ажиллаж байна.

ЭКО ХЭРЭГЛЭЭ, ЦЭВЭР АГААР

Хас банкнаас санаачлан нийслэлийн агаарын бохирдлыг багасгах шинэлэг загварыг боловсруулсан төсөлд хамтран оролцож тус бүтээгдэхүүнийг даатгалд хамруулан цэвэр агаар төслийг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцон дэмжин ажиллаж байна.

Түүнчлэн дотоод хэрэгцээнд ашиглагддаг бал, цаас зэргийг дахин боловсруулсан цаасан материалар хийлгэж ногоон байгаль, ой модоо хайрлах эх үйлст хувь нэмрээ орууллаа. Хаягдал цаас болон цаасны хэрэглээг багасгах талаар дотоод ажиллагсдын дунд сургалт ухулга хийн хаягдал цаасыг дахин боловсруулах үйлдвэрт тушааж, архив санхүүгийн бичиг баримтыг цахим системд шилжүүлэн ажиллаж байна.



ДААТГАЛЫН ГАЗРЫН ТАЙЛАН



Б. Хишигтөр
Даатгал эрхэлсэн захирал

A handwritten signature in black ink, appearing to read 'Б. Хишигтөр'.



Тэнгэр Даатгал ХХК нь өөрийн ажиллагсад болон стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллагч байгууллагууд, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хөдөө орон нутгийн салбарууд, түүний төлөөлөгчөөр дамжуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулалттай, төрийн болон төрийн бус, хувийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, бизнесийн ёс зүйг эрхэмлэн илүү өргөн хүрээнд үйлчлэхээр хичээл зүтгэл гарган ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өсөж, үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн даатгалын талаарх ойлголт улам нэмэгдэж байна. Энэ утгаараа Монголын даатгалын зах зээл болон энэ салбарт ажиллаж байгаа боловсон хүчний мэдлэг чадвар олон улсын түвшинд хүрэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Тэнгэр Даатгал компани даатгалын салбарт тулгарч буй энэхүү шаардлагыг хангаж ажиллахын тулд даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, гэрээний нөхцлийг олон улсын түвшинд хүргэх, ажиллагсдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч, даатгалын зах зээлд мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн ажиллаа.


Бид 2013 онд олон улсын жишигт хүрсэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэ харилцагч болон олон жил хамтран ажиллаж байгаа үнэ цэнэтэй харилцагч нартаа тусгайлан зориулж, учирч болох эрсдэлийн хэмжээг тодорхойлж, тэрхүү эрсдэлүүдийг хэрхэн багасгах, хаах, эрсдэлийн шийдэл, гарцыг олоход нь зөвлөгөө өгөх замаар эрсдэлийг хамтран удирдаж, зарим тохиолдолд тухайн байгууллагын дотоод дүрэм журамд аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах санал, зөвлөгөөг өгч ажиллаа.

Байгууллага хувь хүмүүс даатгалд хамрагдснаар өөрийн хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад эсвэл бусдад санамсар болгоомжгүйн улмаас хохирол учруулахад хохирлоо хэсэгчлэн төлүүлдэг байсан бол эрсдэлээ удирдуулснаар тухайн байгууллага өөрт болон бусдад учруулж болох эрсдэлийг урьдчилан мэдэх, түүнийг бууруулах, мөн эрсдэлээ бүрэн хамгаалуулдаг боллоо. Энэ нь харилцагч байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, төлөвлөгдөөгүй зардлыг бууруулах чухал алхам болсон бөгөөд бид даатгалын салбарт харилцагчийн халамжийн үйлчилгээг дахин нэг шат ахих боломжийг бүрдүүлээ.

Компанийн байгууллагын харилцагчийн тоо, хураамжийн орлогын хэмжээ жилээс жилд тогтвортой өсөж байгаа ба 2013 онд бид 6000 гаруй үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай компани, төрийн болон төрийн бус байгууллагуудад тэдний үйл ажиллагаанд тохирсон даатгалын цогц бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн, учирсан санхүүгийн болон бусад хохирлыг барагдуулан ажиллаа. Байгууллагын харилцагчийн тоо өмнөх онтой харьцуулбал 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд бид төрийн болон олон улсын байгууллагын даатгалын нээлттэй тендер, сонгон шалгаруулалтад амжилттай оролцож, даатгалын үйлчилгээг үзүүлэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажилласан бөгөөд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт зохиогдсон томоохон үзэсгэлэн яармаг, чуулга уулзалт, форумд оролцон байгууллага болон иргэдэд үзүүлж буй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг өгч ажиллаа.

Даатгалын газар нь Түншлэлийн хэлтэс, Төлөөлөгчийн хэлтэс, Салбарын удирдлагын хэлтэс, Хамтын ажиллагааны хэлтэс болон тэдний төлөөлөгчөөр дамжуулан иргэдийн даатгалын зах зээлд бүтээгдэхүүн сурталчлах, даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна.



Иргэдийн даатгалын хувьд харилцагчийн үйлчилгээг сайжруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг харилцагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан боловсронгуй болгох, харилцагчдад даатгалын үйлчилгээ авах салбар, сувгаа өргөтгөх, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаа.

Тайлант хугацаанд өмнөх жилийн харилцагчийн тоог өсгөх, иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд даатгалын үйлчилгээний төвийн харилцагчийн үйлчилгээний ажилтан, ХасБанк, Улаанбаатар хотын банк, Капитал банк, Чингис Хаан банк, ХасЛизинг, Нэйшнл Лизинг, MW кредит ББСБ, Нандин зоос ББСБ, Ард кредит ББСБ, Саммит компьютер технологи ХХК, Let's travel ХХК зэрэг банк болон банк бус санхүүгийн байгууллага, бусад үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж тэдний төлөөлөгчдөөр дамжуулан иргэдэд даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг улам ойртуулан нэг цэгээс санхүү, даатгалын үйлчилгээг хүргэх бүрэн боломжийг нээн иргэдэд үйлчилгээг ойртуулан ажиллаа.

Иргэдэд даатгалын үйлчилгээг нэг цэгээс хүргэх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн даатгалын үйлчилгээг үзүүлэх, харилцагч нарт даатгалын зөвлөгөөг өгч ажиллах хүрээнд хамтран ажиллагч байгууллагын ажилтан, төлөөлөгч нарт чиглэсэн сургалт, зөвлөгөөнүүдийг тогтмол явуулж, чадавхижуулан ажиллаж байна.

Иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх, тэдэнд бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах ажлын хүрээнд "ДААТГАЛЫН ӨДӨРЛӨГ"-ийг Улаанбаатар хот болон хөдөө орон нугийн салбаруудаар дамжуулан улирал бүр зохион байгуулж, телевиз, сошиал, ФМ радиогоор даатгалын талаарх мэдээлэл, холбогдох хуулиудыг сурталчлах ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллаа.

2013 онд харилцагч иргэдийн тоо 40,000 хол давсан нь бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, харилцагчдын маань бидэнд итгэх итгэл хэвээр байгааг харуулж буй тод илрэл юм.



Иргэдэд даатгалын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх зорилгоор "Санхүүгийн Зохицуулах Хороо", "Монголын Даатгагчдын Холбоо" болон Малын индексжүүлсэн даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалтанд 50 хүн хамрагдаж төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах эрх авсан бөгөөд иргэдэд даатгалын үйлчилгээг хүргэх цар хүрээ улам өргөжиж байна.

ОРОЛЦСОН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



Бид 2013 онд зохион байгуулагдсан “Монголын Эдийн Засгийн Чуулган”, “Finance Mongolia 2013”, “Mining Mongolia 2013”, “Дүнжингарав Экспо 2013”, “Авто Экспо 2013”, “Монголын Тариаланчдын Холбоо-2013”, Авто замын Олон Улсын үзэсгэлэн худалдаа”, Малайз улсын Газ болон Газрын Тосны Үйлдвэрлэлийн чиглэлийн уулзалт, үндэсний болон олон улсын томоохон үзэсгэлэн яармаг, чуулга уулзалтуудад ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн охин компаниудын хамт амжилттай оролцож иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад даатгалын зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаа.



“Нью медиа” групптэй хамтын ажиллагааны хүрээнд хүний нөөцийн бодлого, ирээдүйн боловсон хүчнээ бэлтгэх үүднээс mazaalai.biz сайтад байгууллагын дүр төрх, хүний нөөцийн мэдээллийг байршуулан компанийн мэдээллийг иргэдэд өгч байна.



Иргэд, байгууллагад даатгалын боловсрол олгох, даатгалын ач тусыг ойлгуулах зорилгоор даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний видео танилцуулгыг хийж харилцагчдад хүргэж, телевиз, ФМ радиогоор сурталчлан ажиллаж байна.



Монгол Улсын “Санхүүгийн Зохицуулах хороо”, “Албан журмын Даатгагчдын Холбоо” болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Даатгалын нээлттэй өдөрлөг”-үүдийг зохион байгуулж иргэдэд даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын боловсрол, зөвлөгөө өгч ажиллаа.



Эрсдэлийн шинжилгээ: Бидэнтэй харилцагч байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийн шинжилгээ хийх ажлыг олон улсын түвшинд амжилттай зохион байгуулж тухайн харилцагчийн эрсдэлийг бууруулан ажилласан ба тус ажлыг цаашид уламжлал болгон зохион байгуулан ажиллах боллоо.



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулсан шилдэг аж ахуй нэгжийн туршлага солилцох сургалт, уулзалтанд оролцож шилдэг аж ахуй нэгжийн туршлагаас хуваалцан компаниудтай хамтын ажиллагааны эхлэлийг тавин ажиллаа.

ЖАРГАЛТАЙ ИРГЭН

Компанийн хэтийн зорилтын хүрээнд иргэн бүрт даатгалын үйлчилгээг хүргэн үйлчлэх ажлын илрэл болгон Монголд анх удаа иргэдийн эрүүл мэндийн цоо шинэ бүтээгдэхүүнийг зохих стандартын дагуу судалгаа шинжилгээний үндэслэлтэйгээр боловсруулж “Жаргалтай иргэн” даатгалын бүтээгдэхүүнийг өлгийдөн авсан билээ.

Бичил бизнес эрхлэгчид болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд 2013 онд 4536 иргэнд Жаргалтай иргэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн ажиллаа. 2012 онтой харьцуулахад харилцагчдын 89%-ийн өсөлттэй байж иргэдийн талархалыг хүлээн авч ажиллаа.




ЛАНГУУ ТҮРЭЭСЛЭГЧДИЙН ДААТГАЛ ТӨСӨЛ

Мөн онд томоохон худалдааны төв, захуудад гарсан гал түймрийн улмаас бичил бизнес эрхлэгчид, дундаж орлоготой иргэдийн бизнест эрсдэл учирч тэдэнд санхүүгийн хохирол учирсан билээ. Иймд бид эдгээр эрсдэлийг бууруулах тэдэнд учирсан санхүү болон эрүүл мэндийн хохирлыг багасгах, шийдвэрлэх зорилгоор Лангуу Түрээслэгчдийн цогц даатгалын үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

ТЕЛЕМАРКЕТИНГ

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг телемаркетингийн үйлчилгээг Монголын даатгалын салбарт анхлан нэвтрүүлж харилцагчид учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын даатгалын боловсролыг нэмэгдүүлэх, даатгалын ач холбогдлын талаар мэдлэг олгох зорилгоор мэдээ, мэдээлэл, эрсдэлийн зөвлөмж, бусад зөвлөгөөг харилцагч нарт хамгийн ойр, дөхөм сувгуудаар долоо хоног бүрт давтамжтайгаар хүргүүлж байгаа нь харилцагчдын талархлыг хүлээгээд байна. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчийн халамжийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, харилцагчийн эргэх холбоог сайжруулах томоохон алхам болсон.

- <http://tengerdaatgal.mn/> /монгол, англи хэлээр/
- <https://www.facebook.com/tengerinsurance> /монгол хэлээр/



ТЭНГЭРЛЭГ МОНГОЛ ИРГЭН

Тайлант онд бага, дунд орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн, тэднийг олон талт эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Тэнгэрлэг Монгол Иргэн” багц даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээлд шинээр нэвтрүүлсэн нь бага хураамжаар олон төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг нээж өгсөн бөгөөд харилцагч иргэдийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн даатгалын бүтээгдэхүүн болж чадлаа.


Бид даатгалын зах зээл дээр иргэдэд хэрэгцээтэй байгаа олон олон шинэ бүтээгдэхүүнүүдийг гаргаж харилцагч нартаа хүргэхээр зорин ажиллаж байна.



ЭРСДЭЛИЙН ГАЗРЫН ТАЙЛАН



П. Эрдэнэхишиг
Эрсдэл эрхэлсэн захирал



$$\frac{dy}{dx} = \frac{y}{x}$$

Posterior = Prior x Likelihood

$$P(\theta | \text{Data}) = \frac{P(\theta) P(\text{Data} | \theta)}{P(\text{Data})}$$

$$\sum_{i=1}^n$$

$$T(x) = (x-1) T(x-1)$$

$$T(n) = (n-1)!, n=1, 2, 3, \dots$$

$$S = X_1 + X_2 + \dots + X_n$$

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус онд эрсдэлийн удирдлагын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

- Эрсдэлийн удирдлагын баг нь компанийн харилцагч болон даатгуулах сонирхолтой шинэ байгууллагуудад эрсдэлийн удирдлагын шинжилгээг цогц байдлаар хийж гүйцэтгэн үйл ажиллагаанд нь нэвтрүүлж учирч болзошгүй эрсдэлүүдийг бууруулан ажиллаа.
- Ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны аюулгүй ажиллах арга барил, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс сургалт зохион байгуулан, осол эндэгдэлгүй, эрүүл ажиллах соёл, зан үйлийг сургаж, оновчтой даатгалын бүтээгдэхүүн санал болгон ажиллаа.
- Харилцагчдад долоо хоног бүр “Эрсдэлийн урьдчилсан мэдээ” хүргэж, харилцагчийн эрсдэлийг удирдан ажиллаа.

ХАРИЛЦАГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Харилцагчдад компанийн цахим хуудас, фейсбүк хуудас, твиттер хаягаар дамжуулан долоо хоног бүр эрсдэлийн урьдчилсан мэдээ хүргэж, харилцагчийн эрсдэлийг удирдан ажиллаа. Харилцагчдад дараах эрсдэлийн урьдчилсан мэдээг хүргэлээ.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдал
2. Агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө
3. Элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэх боломжтой юу?
4. Хөдөлмөрийн эрүүл аюулгүй орчин
5. Ажиллах тав тух
6. Нийслэлчүүдэд тулгамдаж буй нэгдүгээр асуудал: Хөрсний бохирдол
7. Хүн бүр өөрийнхөө хөрөнгийг удирдах боломжтой
8. Мэдээллийн технологийн аюулгүй байдлын хамгийн сургамжтай 20 үйл явдал
9. Шинэ жилийн баярын үеэр эрүүл мэндэд учрах 12 эрсдэл

АКТУАРЫН ШИНЖИЛГЭЭ

Актуарын мэргэжлийн олон улсын стандартыг Монголд нэвтрүүлэх зорилгоор компанийн актуарчийн ур чадварыг дээшлүүлэхийн тулд Монголын актуарчдын нийгэмлэгийн сургалтанд хамруулах, олон улсын мэргэжлийн шат дараалсан шалгалтанд бэлтгэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд олон улсын даатгалын системийн үндсэн стандартыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, даатгалын зах зээлд компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, урт хугацаанд компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үндэс суурийг тавих бүрэн бололцоог нээн ажиллаа.



Мөн компанийн актуарч олон улсын мэргэжлийн “Санхүүгийн Математик”-ын шалгалтанд тэнцэж, Их Британийн Актуарчдын Институтэд гишүүнээр элслээ. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооноос актуарчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай эрх авлаа.

Дотоод ажлын хүрээнд эрсдэлийн удирдлагын багт орж ажиллан тодорхой бус тохиолдлоос учирч болзошгүй эрсдэлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, дотоод үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын баг болон актуарчийн гүйцэтгэсэн ажил нь эрсдэлийн хорооны хэлэлцүүлэгт үндэслэгдэн явдаг нь эрсдэлгүй шийдвэр гаргах нөхцөл бололцоог бүрдүүлж байдаг.

Өнгөрсөн хугацаанд “Тэнгэр Даатгал” ХХК актуарын мэргэжлийг дэмжих зорилгоор өөрийн актуарчдыг дараах арга хэмжээ аван дэмжин ажилласан. Үүнд:

Их Британийн Актуарчдын Институтын гишүүнчлэлийн эрх авах актуарчийн мэргэжлийн шалгалтуудад хамрагдахад санхүүгийн дэмжлэг үзүүлж Монголын Актуарчийн нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтанд хамрууллаа.

ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮНШҮҮД

Тэнгэр Даатгал ХХК нь гэрээгээр хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавхи болон макро эдийн засгийн өөрчлөлт хандлагатай уялдуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн давхар даатгагч нарт эрсдэлээ шилжүүлэн давхар даатгуулдаг.

Компани нь давхар даатгалын бодлого болон давхар даатгалын стратеги төлөвлөгөөний хүрээнд олон улсын эзэлжих зэрэглэл тогтоогч Standard and Poor's, Moody's Fitch зэрэг байгууллагуудаас тогтоосон үнэлгээ түүнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагын дагуу давхар даатгагч тэдгээрийг зуучлах эрх бүхий дэлхийн топ олон улсын брокер компаниудтай үр ашигтай хамтран ажиллаж байна.

Одоогоор бид, дэлхийн даатгалын томоохон зах зээл болох Английн Lloyd's-ын синдикатууд, Kiln Group (Singapore) Limited, Mapfre Asistencia Limited, Allianz Singapore Limited, Asia Capital Reinsurance Limited, Brit Insurance Limited, Torus Insurance (UK) Limited, Allianz Singapore Limited, ACE Group-Worldwide, QBE (Australia & UK), Swiss Reinsurance Company, Chartist (UK) Limited, Liberty Mutual Insurance Europe, Hannover Re, AXA Corporate Solutions, AIG зэрэг АА үнэлгээ бүхий өндөр нэр хүнд, туршлагатай давхар даатгагчид эрсдлээ тэргүүлэх зэргийн давхар даатгалын брокер болох AON UK Limited, Arthur J.Gallagher UK Limited, Marsh, J.B.Boda, Carroll London Markets (UK) Limited, JLT (Jardine Lloyd Thompson) зэрэг компаниудаар дамжуулан эрсдлээ шилжүүлж олон жилийн турш тогтвортой хамтран ажиллаа.




ХАМТЫН АЖИЛЛАГАА БҮХИЙ ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИУД

ШИНЭ ХАРИЛЦАА-ТҮНШҮҮД

2013 онд бид дараах давхар даатгалын компани, брокеруудтай шинээр харилцаа тогтоон, хамтран ажиллаа.

Үүнд:



Мөн AXA Corporate Solutions Assurance олон улсын давхар даатгалын компанитай фронтингийн үйл ажиллагаа эрхлэн явуулахаар харилцаа тогтоож ажиллаж байна. Тус онд бид хамтран ажилладаг олон улсын давхар даатгалын брокер болон давхар даатгагч нартай хамтын ажиллагаагаа бэхжүүлж мөн ажиллагсдынхаа хөгжил дэвшилт, карриерт анхаарч сургалт семинарыг зохион байгуулж ажиллаа.

Английн Ламп Сервис Лимитид компанитай хамтарч нийт ажилчиддаа олон улсын эрүүл мэндийн даатгалын сургалтыг явуулсан. Үүгээр бид дэлхийн жишигт нийцсэн боловсон хүчинтэй компани болоход нэг алхмаар урагшлахын зэрэгцээ Монголын даатгалын зах зээлд мэргэжлийн стандартыг тогтооход хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Олон улсын эрүүл мэндийн даатгалаар бид гадаадын эмнэлэг рүү чиглэж байгаа мөнгөний урсгалыг багасгахын тулд ард иргэдийнхээ эрүүл мэндийн асуудалд анхаарч эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь бидний нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр юм. Компани Олон Улсын Эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг Монголын даатгалын зах зээл дээр амжилттай нэвтрүүлж харилцагчдаас сайшаагдаад байгаа билээ.

Мөн J. V. Boda Surveyors Pvt., Ltd болон J. V. Boda&Co (S) PTE LTD хамтран эрсдлийн шинжилгээ, агаарын хөлгийн даатгал, давхар даатгалын гэрээний тухай сургалтыг нийт ажилчид хамт олон, харилцагч байгууллагуудыг хамарсан сургалтыг зохион байгуулсан.

Бид цаашид олон улсын харилцаараа дамжуулж дотоодын даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулж хүн бүрт даатгалын боловсролыг хүргэхийн төлөө ажиллаж байна.

ДАВХАР ДААТГАЛЫН БОДЛОГО

2013 онд эрсдэлийг шилжүүлэн хамтран ажиллах давхар даатгагчийг сонгон шалгаруулж, давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа дараах бодлогыг баримтлан ажиллаа. Үүнд:


- Мэргэжлийн өндөр ёс суртахууныг баримтлан бизнесийн ил тод шударга байдлыг үргэлж эрхэмлэн, харилцан хүндэтгэсэн байр сууриас хандан ажиллах;
- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Standard & Poor's, Moody's, Fitch Rating болон A.M.Best зэрэг агентлагуудаас BBB буюу түүнээс дээш зэрэглэл бүхий давхар даатгагч байгууллага, Ллойдсын синдикатуудтай урт хугацааны үр ашигтай хамтын ажиллагааг тогтоон ажиллахыг тэргүүн зорилгоо болгох;
- Дээрх зэрэглэл бүхий давхар даатгагч байгууллагыг зуучилж чадахуйц олон улсад өндөр нэр хүнд, олон жилийн туршлага бүхий давхар даатгалын брокерийн компаниудтай хамтран ажиллах;

Тайлант хугацаанд давхар даатгалын хэлцлийг удаа дараа байгуулж ажилласан бөгөөд уул уурхай, барилга угсралт, үйлдвэр үйлчилгээний байгууллагууд руу илүү чиглэсэн үйл ажиллагааг явуулсан. Үүнтэй уялдуулан давхар даатгалын томоохон компаниудтай харилцаа холбоо шинээр тогтоолоо.


Олон улсын өндөр нэр хүндтэй давхар даатгагч, мэргэжлийн брокерийн компаниудтай харилцан, шинээр харилцаа тогтоох, хуучин түншүүдтэйгээ харилцаа, хамтын ажиллагаагаа улам бататгах, шинэ түвшинд хүргэх, даатгалын шинэ шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн зах зээл дээр хөрвүүлэн нэвтрүүлж, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого баримлан ажиллаа.

БАЙГУУЛСАН ГЭРЭЭ ХЭЛЦЛҮҮД

2013 онд нийт 3.1 тэрбум төгрөгийн хариуцлагыг давхар даатгалд FacQshare хэлбэрээр шилжүүлэн эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу агаарын хөлгийн их бие, агаарын хөлгийн хариуцлага, эд хөрөнгө, нефт бүтээгдэхүүн, олон улсын болон дотоод ачаа тээвэр, байгууллага ба бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлага, удирдах ажилтны хариуцлага, цахим гэмт хэрэг, банкны бүрэн даатгал, гадаадад зорчигчийн иж бүрэн даатгалын хэлбэр тус бүрээр эрсдэлийг 70% - 100% давхар даатгалд шилжүүлэн ажиллаа.



Давхар даатгалд шилжүүлсэн нийт хариуцлагыг даатгалын төрлүүдээр дэлгэрэнгүй харуулбал 63% барилга угсралтын хариуцлагын даатгал, 7% эд хөрөнгийн даатгал, 2% удирдах ажилтны хариуцлагын даатгал, 6% нефтийн бүтээгдэхүүний даатгал, үлдсэн хэсэг агаарын хөлгийн их бие, түүний хариуцлага, операторын илүү зардал, ерөнхий хариуцлага, банкны бүрэн ба цахим гэмт хэргийн даатгал эзэлж байна.



Тэнгэр Даатгал ХХК нь Mapfre Asistencia LLC-тай хамтран гадаадад зорчигчийн иж бүрэн даатгал, Hannover Re-тэй хамтран эд хөрөнгө, барилга угсралт, ачаа тээвэр, ерөнхий хариуцлага, ажил олгогчийн хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн осол, хүнд даацын болон тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл машин механизмын даатгалаар гэрээ хэлбэрийн давхар даатгалын гэрээ байгуулан ажиллаа.

ДАВХАР ДААТГАЛААС БАРАГДУУЛСАН НӨХӨН ТӨЛБӨР

Бид 2013 онд нефть бүтээгдэхүүн, эд хөрөнгө, гадаадад зорчигчдын иж бүрэн даатгал, олон улсын эрүүл мэнд гэсэн даатгалын төрлүүдээр давхар даатгагчаас нийт 31 тохиолдлоор 139.24 сая төгрөгийн нөхөн төлбөрийг нэхэмжлэн барагдууллаа.



ГЭРЭЭТ ДАВХАР ДААТГАЛЫН ГЭРЭЭ ХЭЛЦЛҮҮД


Солонгосын Samsung fire and Marine Insurance компанитай хамтын ажиллагаа тогтоож Монголын Зам Тээвэр Аялал Зуулалын Яам Төмөр зам тавих бүтээн байгуулалтын ажлын хариуцлагын даатгалын гэрээг байгуулан эрсдлийг шилжүүлэн ажилласан нь 2013 оны давхар даатгалын онцлох үйл явдлуудын нэг байлаа.

Мөн олон улсын нэр хүнд бүхий уул уурхайн Rio Tinto, Leighton Holdings компаниудын болон Standard Chartered Bank- ны эрсдлийг шилжүүлэн ажилласан нь бидний хувьд нэр хүндтэй хэрэг байлаа.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нөхөн төлбөрийн үйл ажиллагааны чиглэл нь харилцагчийнхаа өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, учирсан хохирлыг барагдуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах явдал юм. Бидний зорилгын хүрээнд бодит нөхөн төлбөрийг эрсдэлд орсон харилцагчдад хүртээмжтэй хүргэхэд оршино.


Даатгагдсан харилцагч бүрийн эрсдэлийг бууруулах, учирсан хохирлыг бага зардлаар даван туулах нь даатгуулагч, даатгагчийн хамтын ажиллагааны гол зангилаа бөгөөд харилцагчийн даатгалын тохиолдол учирсны дараах бодит хохирлыг түргэн шуурхай шийдвэрлэх нь нөхөн төлбөрийн хамт олны гол баримтлах бодлого юм.




Манай нөхөн төлбөрийн алба жилийн 365 хоног 24 цагийн туршид ослын дуудлагыг хүлээн авч ослын газарт очиж хохирлыг баталгаажуулж түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэн ажилласаар ирлээ. Түүнчлэн бид ослын газарт цаг алдалгүй очиж ажиллах үүргээ биелүүлэхээр "Auto SOS" ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтын ажиллагаа үйлчилгээг сайжруулан ажиллаж байна.

Байгалийн гамшиг, зам тээврийн осол, гал түймэр, ус, үерийн аюулд өртсөн, гэнэтийн цочролд орсон олон арван хүнд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл санааны дэмжлэг өгөх чухал үүрэг бүхий дуудлагын ажилтнуудын оролцоо их байлаа. Тайлант онд дуудлагын ажилтнуудын ослын газарт очиж ажиллагаа хийгдсэн тоо 3548 байлаа.


Нөхөн төлбөрийн алба боловсон хүчний тоог нэмэгдүүлэлгүйгээр тайлант жилийн хугацаанд 4455 харилцагчийн материал шийдэж, 1.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгож санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Олгосон нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-ийн өсөлттэй байна.



Тайлант онд албан журмын Жолоочийн хариуцлагын даатгал "Тэнгэр даатгал" ХХК-ийн нийт нөхөн төлбөрийн 42 хувийг, авто тээврийн хэрэгслийн даатгал 30 хувийг тус тус эзэллээ. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд өмнөх оны мөн үеэс 78.5 хувиар өссөн байна. Компанийн хувьд 2013 онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр олголт 851 сая төгрөг байлаа.



Тайлант онд даатгуулагчийн тоо 42.6 мянгаар өсч, нөхөн төлбөр олгосон харилцагчийн тоо 4.7 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 82%-иар өссөн байна.




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТАЙЛАН



Д. Энэбиш
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ИЙН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2012 онд нийт актив 7,819.0 сая төгрөг байсан бол 2013 оны эцэст нийт актив 11,705.0 сая төгрөг болж 3,886.0 сая төгрөг буюу 50%-р өссөн байна. Нийт актив 50%-р өсөхөд богино хугацаат хөрөнгө оруулалт 4,765.0 сая төгрөгнөөс 6,700.0 сая төгрөг болж 1,935.0 сая төгрөг буюу 41%-р, харилцах дансан дахь мөнгөн хөрөнгө 57.2 сая төгрөгнөөс 445.9 сая төгрөг болж 388.7 сая төгрөг буюу 680%-р өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Нөөц сангийн хувьд 2012 онд 5,038.0 сая төгрөг байсан бол 2013 онд 7,112.4 сая төгрөг болж 2,074.5 сая төгрөг буюу 41%-р өссөн үзүүлэлттэй байна.

Эздийн өмчийн хувьд 2012 онд 2,371.8 сая төгрөг байсан бол 2013 онд 3,953.1 сая төгрөг болж тайлант үеийн цэвэр ашиг болох 831.3 сая төгрөг болон дүрмийн сангийн 750.0 сая төгрөг нийт 1,581.3 сая төгрөг буюу 67%-р өссөн.

Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

2012 онд нийт даатгалын хураамж 6,030.8 сая төгрөг байсан бол 2013 онд 8,512.1 сая төгрөг болж өмнөх оноос 2,481.3 сая төгрөг буюу 41%-р өссөн байна.

Нийт олгосон нөхөн төлбөр 2012 онд 1,690.9 сая төгрөг байсан бол 2013 онд 2,042.6 сая төгрөг болж өмнөх оноос 351.7 сая төгрөг буюу 21%-р өслөө.


Хөрөнгө оруулалтын орлого 2012 онд 663.2 сая төгрөг байсан бол 2013 онд 855.2 сая төгрөг болж 191.9 сая төгрөг буюу 29%-р өссөн байна.

Санхүүгийн харьцаа үзүүлэлт

2013 онд компанийн ашигт ажиллагаа нэмэгдснээр 2012 онтой харьцуулахад өөрийн хөрөнгийн өгөөж 8%-с 30% -д, нийт активын өгөөж 3%-с 10%-д хүрсэн. 2012 онд хохирлын харьцаа 36%, зардлын харьцаа 61% нийлмэл харьцаа 96% байсан бол 2013 онд хохирлын харьцаа 37%, зардлын харьцаа 57% нийлмэл харьцаа 94% болж өөрчлөгдсөн үзүүлэлттэй байна.



Нөхөн төлбөр авагч байгууллага, иргэдийн тоо 2012 онд 2592 байсан бол 2013 онд 4467-д хүрч өмнөх оноос 72% өссөн байна.



Эрдэнэт хүмүүн - Шавхагдашгүй баялаг

Тэнгэр даатгалын ажилтнууд мэргэжлийн өндөр чадвартай, туршлагатай, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг байх нь бидний амжилтыг тодорхойлогч гол хүчин зүйл юм.

Бид чадварлаг ажилтнуудыг татах, хөгжүүлэхийн тулд ажлын таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, шагнал урамшууллын нэгдсэн бодлого журам, албан тушаал ахиж дэвших өргөн боломжуудыг бий болгохыг зорин ажиллаа.

Ажлаа зөв сонгохоос амжилт эхэлдэг уриан дор бүрдүүлэлтийн аяныг өнгөрсөн жил амжилттай эхлүүлж, хэрэгжүүлсэн бөгөөд даатгалын салбарын чадварлаг мэргэжилтнүүдийг татах, түүнчлэн залуу, шинэ төгсөгчдөд чиглэсэн байснаараа онцлог байлаа.

Тайлант онд 96 ажилтантай байсаны 75 хувь нь харилцагчдад үйлчилгээ хүргэдэг тэргүүн шугаманд ажиллаж байна. Үлдсэн 25 хувь нь төвийн нэгж болон дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

2013 онд компанийн хоёр ажилтан Монгол улсын даатгалын салбарийн шилдэг ажилтанаар шалгарч шавхагдашгүй арвин туршлага бүтээмжтэй ажиллаж хамт олноо манлайлав.

Ажиллагсдыг урамшуулан, хөгжүүлж халамжлах нь

Ажилтнуудаа урамшуулж, хөгжүүлэх зорилготой “Урамшууллын багц хөтөлбөр” -ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд ажилтнууд ажилдаа илүү анхаарах, ажлаа дээд зэргийн чанартай, стандартын дагуу гүйцэтгэхэд энэхүү хөтөлбөр чиглэгддэг. Үүнд:

- **Тэтгэврийн нэрийн сан:** Олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтнуудаа урамшуулах, тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн хувьд баталгаатай байх боломжийг бий болгох зорилгоор тэтгэврийн нэрийн дансыг бүх ажиллагсдаа нээн өгч ирээдүйд нь хөрөнгө оруулалт хийлээ.
- **Орон сууцны хөнгөлөлттэй зээл:** Толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон Хас банктай хамтран “Ажиллагсдын орон сууцны хөнгөлөлттэй зээл” хөтөлбөрийг 4 дэхь жилдээ амжилттай хэрэгжүүлснээр урт хугацаанд нийгмийн тогтвортой байдлыг нь хангаж залуу гэр бүлүүдэд бодитой дэмжлэг үзүүлж ажилласаар байна.
- **Эрүүл аюулгүй орчин:** Ажилтнууд эрүүл, аюулгүй ажиллах нь хамгийн чухал тул 2013 онд нийт ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд хамруулан эрүүл зөв амьдрах орчинг бүрдүүлэн ажиллаа.
- **Цалин урамшуулал хангамж:**
 - Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ тогтвортой өсч манлайлан ажиллаж буй ажилтан бүрт улирал тутам урамшууллын цалингаа өсгөх боломжийг олгон уян хатан системийг улам бататган ажиллаа.
 - Ажиллагсдийн бүтээлч, өөриймсөг ажиллах сэтгэл ханамжийг дээшлүүлэх, зах зээлд манлайлах нүүр царайг илтгэх зорилгоор жилд нэг удаа хувцасны төлбөрийг олгон ажиллаж байна.



Сургалт ба хөгжил

Ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үүднээс Даатгалын үйл ажиллагааны шаардлагад нийцсэн сургалтын бодлогыг ажиллагсдын хэрэгцээ, шаардлага болон тэдгээрийг өсөн хөгжих бусад хэрэгцээнд суурилан боловсруулж тогтмол зохион байгуулдаг.

Ажиллаж буй албан тушаалдаа өсөх мэдлэг, чадвартай ажиллагсдыг нээн илрүүлэх, компанийн үйл ажиллагаанд нэн хэрэгцээтэй нарийн мэргэжил шаардсан аливаа албан тушаалд залгамж боловсон хүчнийг бэлтгэх, хөгжүүлэх арга хэмжээг байнга хэрэгжүүлдэг.

Мөн даатгуулагчдын боловсролд зориулсан өргөн цар хүрээтэй сургалтуудыг зохион байгуулж ажилладаг билээ.


Үүнээс:

“Бизнес ба Логистик” сургалт: 2013 оны 2 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд МХАҮТ-ийн зураасан код, логистикийн хэлтсээс зохион байгуулсан “Бизнес ба Логистик” сургалтанд амжилттай оролцсон.

Сургалтанд 30 гаруй байгууллагын 40 орчим ажиллагсад хамрагдаж логистикийн бизнест гүйцэтгэх үүрэг, зохицуулалт, агуулах, түгээлт, нөөцийн менежмент, логистикийн сүлжээ ба инкотермс 2010 зэрэг агуулгаар сургалтыг зохион байгуулсан.

Нийт ажилтнуудад зориулсан сургалтуудын тоо, давтамж ихэсгэхийн зэрэгцээ агуулга, хөтөлбөр илүү боловсронгуй болж, мэргэжлийн хөгжил, харилцагчдаа халамжалх бодлоготой ажиллах болсон. Мөн групп болон компанийн хэмжээнд урлаг, спортын олон үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд зохион байгуулдаг нь манай ажилтнуудын урт хугацаанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж буйд түлхэц үзүүлж буй нэг гол үзүүлэлт юм.

“ХасБанк” Хүний Нөөцийн Өдөрлөг: ХасБанкны ажиллагсдад эрүүл мэндийн даатгалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөмж өгч мөн бусад сонирхсон бүхий л төрлийн даатгалын хамгаалалтын талаарх мэдээллийг өгч ажиллаа.



Ажлын таатай орчин

Төв, баруун, зүүн бүсэд орчин үеийн жишиг бүхий, ажлын байрны стандартын шаардлага хангасан тохижилттой даатгалын үйлчилгээний төвүүдийг бий болголоо. Ялангуяа орон нутагт өөрийн анхны оффисын байр, машинтай болж ажиллаа.

Оффисын дотоод зохион байгуулалтыг ажлын чиг үүрэг, уялдаа холбоо, дотоод мэдээлэл түргэн дамжуулах зэрэг үзүүлэлтийг харгалзан үзэн газар тус бүрээр зохион байгуулах ажлыг бүрэн боловсруулан дуусгалаа.



Групп компани болон компанийн зүгээс зохион байгуулагддаг олон нийтийн арга хэмжээнд нийгмийн хариуцлага нөгөө талаас ажилчдын дотоод уур амьсгалыг сайжруулах, нэгдмэл нэг гэр бүл бий болгох зорилгоор олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулан амжилттай ажиллаа.

Олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцсоор ажилчид бие биесээ улам танин мэдэж ингэснээр дотоод ажлын бүтээмж, дотоод мэдээлэл дамжуулах хурд дээшлээд зогсохгүй ажилтан албан хаагчдын ар гэрийн зүгээс магтаал, сайшаал талархалын үг олноор хүлээн авч байгаа нь бидний ажлын бодит үр дүн билээ.

Мэдээлэл технологи

Цаг хугацаатай өрсөлдөн хурдацтайгаар өөрчлөгдөж байгаа мэдээлэл технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахыг зорилго болгон ажилласаар ирсэн. Байгууллагын хүрээнд хүний нөөцийн Green-ERP цогц програмыг шинээр нэвтрүүлж ажиллаа. Энэхүү програм хангамж нь ажилтан болон удирдлага бие биенээ хянах, цаг бүртгэл, ирцээ өдөр, долоо хоног, сар, жилээр хянах, цалин, урамшуулал, ээлжийн амралт гэх зэрэг ажиллагсдын талаарх мэдээллээ бүрэн шийдэх боломж олгодог ороо онцлог давуу талтай програм юм.



Мөн ИнфоСофт ХХК-тай хамтран HeavenPro даатгалын цогц програмыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж ажилласнаас хойш Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлага, дотоод мэдээлэл боловсруулах шаардлага зэрэг цаг үетэйгээ урган гарсан бусад шаардлагуудыг тухайн програмд тасралтгүй хөгжүүлэлт хийн улам, боловсронгуй болгон ажиллаж байна.

Харилцагч байгууллага, иргэддээ бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам ойртуулахын тулд вебэд суурилсан онлайн даатгалын тогтолцоог салбартаа анхдагч байдлаар цогцоор нь шийдэхээр ажиллаж байна.


Олон нийтийн арга хэмжээнүүдээс дурьдвал: Байгууллагын Март-8 болон Цэргийн баярын арга хэмжээг амжилттай зохион байгуулж газар хэлтсүүд 100% ирцтэй оролцлоо.



“С1 телевиз”-ээс зохион байгуулдаг “Нийслэлийн хэмнэл” цэнгээнт нэвтрүүлэгт “DOZ entertainment”-ийн уран бүтээлчидтэй хамтран оролцож хамт олны идэвхийг нэмэгдүүлсэн.



“Хас Суп Спортын өдөрлөг – 2013” тэмцээнд багаараа 5-р байр эзэлсэн.



“Дуган хад”, “Хамрын хийд”-ийн аялал, Halloween 2013 арга хэмжээг анх удаа зохион байгуулж, ажиллагсад идэвхитэй оролцлоо.



Баг хамт олондоо тавтай морил



Шинэ жил



Хөдөө орон нутгийн салбарын ажиллагсдын ээлжит сургалтыг явуулж, даатгалын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж ажиллаа.



ХасБанкны хүний нөөцийн албанаас зохион байгуулсан “Train the Trainer” сургагч багшийн сургалтанд оролцсон.



“Петровис-2013” спорт арга хэмжээ: “Тэнгэр Даатгал” ХХК уг тэмцээнээр эмэгтэй баг сагсан бөмбөг 1-р байр алтан медаль, гар бөмбөг 1-р байр алтан медаль нийлбэр дүнгээрээ 2-р байр эзэлсэн.



GreenERP хүний нөөцийн систем

Өнөө цагт байгууллагын хүний нөөцийн албаны гол үүрэг нь чадварлаг ажиллах хүчний мэдлэг, оюунд тулгуурлан байгууллагынхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дэвшүүлсэн зорилгодоо хүрэхэд байгууллагын хүний нөөцийг чиглүүлэх, хувь хүний чадварыг бүхий л талаар хөгжүүлэхэд шаардлагатай нөхцлийг бий болгох үүднээс 2013 онд М-СИ-ЭС Электроникс ХХК-тай хамтран GreenERP Хүний нөөцийн системийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхэлсэн.

GreenERP Хүний нөөцийн системийг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэнээр ажиллагсдын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавихын зэрэгцээ зах зээлийн шинэ хандлага, чиглэлийг тодорхойлох, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх зэрэгт илүүтэй анхаарал хандуулан ажиллах болсон.



ХҮНИЙ НӨӨЦИЙН СИСТЕМ НЬ ҮНДСЭН 5 ДЭД МОДУЛИАС БҮРДДЭГ.

- Хүний нөөц
- Цаг бүртгэл
- Цалин
- Хүний нөөцийн портал
- Онлайн анкет

Хүний нөөцийн систем нь байгууллагын хүний нөөцийн удирдлагын боломжит бүх үйл ажиллагааг автоматжуулж, байгууллагын удирдлагын зардал, цаг хугацаа, механик үйлдлүүдийг багасгаж, ажилтнуудын бүтээмж, үр ашиг, цаг ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тэнгэр Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Бид Тэнгэр Даатгал ХХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь компанийн удирдлагын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторчуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Тэнгэр Даатгал ХХК –ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Тэнгэр Даатгал ХХК -ийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Тэнгэр Даатгал ХХК -ийн эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.




ПЕТР МАРКИ
Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2014 оны 3 дугаар сарын 28



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан

	2013 мян.төг	2012 мян.төг
ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	968,352	929,358
Биет бус хөрөнгө	18,440	27,640
Үйл ажиллагааны авлага	1,004,059	1,200,558
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	1,934,857	406,536
Бараа материал	56,424	37,672
Урьдчилж төлсөн зардал	54,380	29,340
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	522,134	365,265
Богино хугацаатай хадгаламж	6,700,000	4,765,000
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	445,878	57,162
НИЙТ ХӨРӨНГӨ	11,704,524	7,818,531
ӨР ТӨЛБӨР		
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлийн нөөц	1,367,651	1,303,821
Болзошгүй хохирлын нөөц	1,144,344	833,219
Давхар даатгагчид төлөх өглөг	348,081	132,025
Орлогын албан татварын өглөг	32,769	35,202
Бусад өглөг	104,484	114,253
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	4,600,409	2,900,816
Хойшлогдсон орлого	153,677	127,390
НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,751,415	5,446,726
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Энгийн хувьцаа	2,750,000	2,000,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Хуримтлагдсан ашиг	1,073,109	241,805
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	3,953,109	2,371,805
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,704,524	7,818,531

ОРЛОГЫН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	2013 мян.төг	2012 мян.төг
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	6,724,509	5,195,801
Давхар даатгагчид ногдох хураамж	(1,571,674)	(962,661)
Орлогод тооцсон цэвэр хураамж	5,152,835	4,233,140
Давхар даатгалын шимтгэлийн орлого	111,709	70,764
Бусад үйл ажиллагааны орлого	889,228	663,184
Бусад орлого	1,000,937	733,948
Нөхөн төлбөр	(2,417,730)	(2,238,419)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	139,244	96,321
Цэвэр нөхөн төлбөр	(2,278,486)	(2,142,098)
Бусад үйл ажиллагааны ба удирдлагын зардал	(2,948,572)	(2,574,562)
Бусад орлого	10,264	19,947
Бусад зардал	(2,938,308)	(2,554,615)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	936,978	270,375
Орлогын албан татварын зардал	(105,674)	(66,318)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ	831,304	204,057
Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг	831,304	204,057

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Дүрмийн сан мян.төг	Нэмж Төлөгдсөн Капитал мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт Хөрөнгө мян.төг
2012.01.01-ний өдрийн байдлаар	1,000,000	130,000	1,037,748	2,167,748
Нийт дэлгэрэнгүй орлогын илэрхийлсэн тайлант жилийн ашиг	-	-	204,057	204,057
Дүрмийн санд шилжүүлсэн	1,000,000	-	(1,000,000)	-
2012.12.31 ба 2013.01.01-ний өдрийн байдлаар	2,000,000	130,000	241,805	2,371,805
Нийт дэлгэрэнгүй орлогын илэрхийлсэн тайлант жилийн ашиг	-	-	831,304	831,304
Гаргасан энгийн хувьцаа	750,000	-	-	750,000
2013.12.31-ний өдрийн байдлаар	2,750,000	130,000	1,073,109	3,953,109

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн мөнгөн гүйлгээний тайлан

	2013 мян.төг	2012 мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	936,978	270,375
Тохируулга:		
Хүүгийн орлого	(855,170)	(663,184)
Валютын ханшийн бодит бус ашиг	(1,402)	(3,500)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	78,240	62,225
Биет бус хөрөнгийн хорогдол	12,940	12,310
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	680	2,061
Найдваргүй авлагын сан	28,159	-
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагаанаас орсон мөнгөн гүйлгээ	200,425	(319,713)
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт		
Хойшлогдсон даатгалын зардлын (өсөлт)/бууралт	(156,869)	(217,089)
Бараа материалын (өсөлт)/бууралт	(18,752)	(15,697)
Урьдчилж төлсөн зардлын (өсөлт)/бууралт	(25,040)	(17,466)
Бусад авлагын (өсөлт)/бууралт	182,808	(257,451)
Давхар даатгагчаас авах авлагын (өсөлт)/бууралт	(6,180)	4,614
Бусад өглөгийн өсөлт (бууралт)	(9,769)	(43,188)
Давхар даатгагчид төлөх өглөгийн өсөлт/(бууралт)	216,056	(141,467)
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өсөлт/(бууралт)	171,272	885,049
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлийн нөөцийн өсөлт/(бууралт)	374,955	634,452
Хойшлогдсон комиссын орлогын өсөлт/(бууралт)	26,287	89,050
Үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/-наас орсон мөнгөн гүйлгээ	955,193	601,094
Төлсөн орлогын албан татвар	(108,107)	(55,072)
Үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/-наас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	847,086	546,022
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан хүү	846,882	527,934
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(132,825)	(181,514)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(3,740)	(32,450)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	14,911	4,000
Санхүүгийн хөрөнгө оруулалтын өөрчлөлт	-	-
Гурван сараас дээш хугацаатай банкуудад байршуулсан хадгаламжийн өөрчлөлт	(1,935,000)	(977,000)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/ -наас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	(1,209,772)	(659,030)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Энгийн хувьцаа гаргаснаас хүлээн авсан	750,000	-
Санхүүгийн үйл ажиллагаа (-нд зарцуулсан)/ -наас	750,000	-
Орсон цэвэр мөнгөн гүйлгээ		
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ/(БУУРАЛТ)	387,314	(113,008)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд нөлөөлөх ханшийн зөрүү	1,402	3,500
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,162	166,670
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	445,878	57,162



ТЭНГЭР ДААТГАЛ
Төлөөллийн МЭНДЭГЭЛ



Архангай

Утас: 7033-2058
Гар утас: 9933-6855, 9966-5716
И-мэйл: arkhangai@tengerdaatgal.mn
Хаяг: Архангай аймаг, Цэцэрлэг сум,
Ахмадын өргөөний 2 давхар

Багануур

Утас: 7021-2122
Гар утас: 9900-9629, 9994-1284
И-мэйл: baganuur@tengerdaatgal.mn
Хаяг: Багануур дүүрэг 1 хороо
Д.Нацагдоржийн гудамж
Наран хороолол "Мэдээлэл холбоо
сүлжээ" ТӨК-ний байр 1 давхар

Баян-өлгий

Утас: 7042-2002
Гар утас: 9942-2912, 9942-2299
И-мэйл: bayan-ulgai@tengerdaatgal.mn
Хаяг: Баян-Өлгий аймаг, 5-р баг,
21-р бааз НИК-ийн байр 1 давхар

Баянхонгор

Утас: 7044-4044
Гар утас: 9944-9423, 8950-9808
И-мэйл: bayankhongor@tengerdaatgal.mn
Хаяг: Баянхонгор аймаг, Баянхонгор сум
Номгон 1-р баг ХХААХХолбоо
Худалдаа Орон сууцны төв
1-р давхар

Булган

Утас: 7034-2598
Гар утас: 8803-0817
И-мэйл: bulgan@tengerdaatgal.mn
Хаяг: Булган аймаг, ХасБанкны байр

Говь-алтай

Гар утас: 9633-2882, 9962-1304
И-мэйл: gobi-altai@tengerdaatgal.mn
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,
Харзат баг 13-22А байрны
3-р давхар 2 тоот

Дархан

Утас: 7037-6898
Гар утас: 9900-5060, 9908-7021
И-мэйл: darkhan@tengerdaatgal.mn
Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум,
8-р баг, Төв ХасБанк 1 давхар

Дорноговь

Утас: 7052-2252
Гар утас: 9903-1374, 9661-0296
И-мэйл: dornogobi@tengerdaatgal.mn
Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд хот,
2-р баг, LUX зочид буудлын байр
1 давхар

Дорнод

Утас: 7058-4141
Гар утас: 9904-8148, 9958-5412
И-мэйл: dornod@tengerdaatgal.mn
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум,
6-р баг, 67 байр, 1 давхарт
ХасБанкны байр

Завхан

Утас: 7046-2237
Гар утас: 9979-1070, 9946-8226
И-мэйл: zavkhan@tengerdaatgal.mn
Хаяг: Завхан аймаг Улиастай сум
Манлай Од ХХК-ны 2 давхарт

Орхон

Утас: 7035-4090, 7035-4091
Гар утас: 9999-6538, 9900-4737, 9935-9500
И-мэйл: alimaa@tengerinsurance.mn
Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨК-ны
байр 1 давхар 101 тоот

Өвөрхангай

Утас: 7032-2998
Гар утас: 9902-4771, 9603-6811
И-мэйл: uvurkhangai@tengerdaatgal.mn
Хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум
Тулга төвийн 1 давхарт

Өмнөговь

Гар утас: 9911-1138, 9903-1166, 8899-7264
И-мэйл: umnugobi@tengerdaatgal.mn
Хаяг: Өмнөговь аймаг, Даланзадгад 3-р баг,
Говийн хөгжлийн ордны
2 давхар 202 тоот

Сүхбаатар

Утас: 7051-2660
Гар утас: 9901-3101, 9889-9061
И-мэйл: sukhbaataraimag@tengerdaatgal.mn
Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум,
3-р баг, Өгөөмөр тооцооны
төвийн 2-р давхар

Сэлэнгэ

Утас: 7036-2211
Гар утас: 9966-2926, 9441-0954
И-мэйл: selenge@tengerdaatgal.mn
Хаяг: Сэлэнгэ аймаг, Сүхбаатар хот,
Төв холбооны байр 1 давхар

Увс

Гар утас: 9609-4515, 9655-2979
И-мэйл: uvs@tengerdaatgal.mn
Хаяг: Увс аймаг, Маршал
Ю.Цэдэнбалын гудамж, 3-р баг,
Монгол Ардын Намын байр,
1-р давхар

Ховд

Утас: 7043-2400
Гар утас: 9943-7024, 9903-7823
И-мэйл: hovd@tengerdaatgal.mn
Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум
МАН байр 1-р давхар 101 тоот

Хөвсгөл

Утас: 7038-3884
Гар утас: 9990-2426, 9903-2794
И-мэйл: khuvsdul@tengerdaatgal.mn
Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум
8-р баг, 15-р байр Хөвсгөл Нэг үе
клубын 2 давхар

Хэнтий

Утас: 7056-2181
Гар утас: 9900-5124, 9606-6288, 9828-2098
И-мэйл: khentii@tengerdaatgal.mn
Хаяг: Хэнтий аймаг, Хэрлэн сум
1-р баг, Тэмүүжингийн гудамж
Монгол банкны байр 1 давхар



Go to web

Төв оффис:

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5, Бага тойруу, 14200
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ш/х-48/258

Утас: (976-11) – 312234
Факс: (976-11) – 319919
Цахим хуудас: www.tengerdaatgal.mn
Цахим шуудан: insurance@tengerinsurance.mn

Улаанбаатар хотын салбарууд:

Их дэлгүүрээс цирк орох замд байрлах
Утас: (976) 7011-2234

Баянгол дүүрэгт байрлах
Утас: (976) 7700-8989



